

Татварын багц хуулийн шинэчлэл



Холбоо барих:

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

PwC Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Та дээрх болон бусад
асуудлаар татварын зөвлөх
үйлчилгээ авахыг хүсвэл
бидэнтэй холбоо барина уу.



Татварын хуулийн шинэчлэл

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгохоор заасны дагуу Сангийн яамнаас Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Татварын ерөнхий хууль (ТЕХ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хууль болон Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, цахим сайтдаа байршуулсан байна.

Эдгээр хуулийн төслүүдэд 2025 оны 4-р сарын 12-ний өдрийг хүртэл олон нийтээс нээлттэй санал авч, сайжруулан зассаны дараа Засгийн газраар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулна. Хуулийн төслүүдийг 2026 оны 1-р сарын 1-нийг эхлэн хэрэгжүүлэхээр бэлдсэн байна.



1. НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон голлох нэмэлт, өөрчлөлтүүд

Хувь хүмүүс үзүүлэх НӨАТ-ын хөнгөлөлт:

- Эцсийн хэрэглэгч хувь хүмүүсийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг сар бүр доорх шатлалаар хөнгөлж, буцаалт олгоно:

Сарын худалдан авалт	Төлсөн НӨАТ-ын хөнгөлөлт /буцаан олголт/ %
500,000 төгрөг хүртэлх	100%
500,000-800,000 төгрөг	50%
800,000 төгрөгөөс дээш	20%

НӨАТ-ын босго:

Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь үргэлжилсэн 12 сарын хугацаанд **400 сая ба түүнээс дээш** төгрөгт хүрсэн этгээд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлнэ.

НӨАТ-ын хасалт:

- Үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг шууд бүрэн хасна.
- Оршин суугч бус этгээдээс худалдан авсан, төлбөрийг бэлэн бусаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд ногдуулсан төлсөн НӨАТ-ыг хасна.
- НӨАТ-ын суутган төлөгч оршин суугч, харилцан хамааралгүй этгээдээс НӨАТ-гүй худалдан авалт хийж төлбөр тооцоог бэлэн бусаар хийсэн бол төлбөрийн дүнд 10%-ийн НӨАТ шингэсэн гэж үзэн хасалт тооцож болно.
- Аж ахуйн нэгжийн суудлын автомашин худалдан авах, импортлох үед төлсөн НӨАТ-ын хувьд хасалт тооцож болно.
- ААНОАТ-ын хуульд заасан хязгаарт багтаан ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, ажилтны сургалт болон хувийн хэрэглээнд төлсөн НӨАТ-ын хувьд хасалт тооцож болно.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болго. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

Татварын багц хуулийн шинэчлэл



Холбоо барих:

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

PwC Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Та дээрх болон бусад асуудлаар татварын зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.



2. ААНОАТ-ын хуулийн хуульд оруулах гол нэмэлт, өөрчлөлтүүд



Ногдол ашгийн татварын чөлөөлөлт, буурсан хувь:

- Монгол Улсад (МУ) байрладаг албан татвар төлөгчийн өөрийн 100 хувь эзэмшдэг аж ахуйн нэгж (ААН)-ээс авсан ногдол ашгийг суутган татвараас чөлөөлнө.
- ААН хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг МУ-д байрладаггүй албан татвар төлөгчид олгосон ногдол ашгийн орлогод 15 хувиар татвар ногдуулна.

Шинэчилсэн албан татварын хувь хэмжээ:

Доор дурдсан салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 2.5 тэрбум төгрөгөөс бага татвар ногдох орлоготой ААН-ийн татвар ногдуулах орлогод 10 хувиар татвар ногдуулж, эцсийн татварын тайлангаар ногдуулж, төлсөн татварыг 90 хувиар хөнгөлж, буцаан олгоно:

- ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;
- согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;
- газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн.

Дээр дурдсанаас бусад албан татвар төлөгчид доор дурдсан хувиар албан татвар ногдуулахаар тусгасан:

Нэмэлт хувийг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтооно.

Татварт ногдох орлого (төгрөг)	Суурь	Нэмэлт
6 тэрбум хүртэлх дүнд	6%	0-4%
6 тэрбумаас давсан 10 тэрбум хүртэлх дүнд	9%	0-6%.
10 тэрбумаас давсан дүнд	15%	0-10%.

Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний татварын харилцаа:

Тусгай зөвшөөрөл (Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн) эзэмшигч нь нэмж хувьцаа гаргаж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор эцсийн эзэмшигчийн хувь оролцоо, саналын эрхийн бүтэц өөрчлөгдсөн тохиолдолд эрх шилжүүлсэн гэж үзэхгүй бөгөөд татвар ногдохгүй гэж тусгагдсан

ААНОАТ-ын хасалт:

Ажилчны хамрагдсан мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхтэй холбоотой гарсан зардал болон ажилчдын хувийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээний зардлыг хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилчдын өмнөх дараалсан 12 сард олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 10 болон 5 хувиас хэтрэхгүй байна.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болго. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

Татварын багц хуулийн шинэчлэл



Холбоо барих:

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

PwC Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Та дээрх болон бусад асуудлаар татварын зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.



3. Татварын ерөнхий хуульд оруулах гол нэмэлт, өөрчлөлтүүд

- Дотоод үнэ шилжилтийн болон Ерөнхий үнэ шилжилтийн тайлангуудыг татварын албанд хүргүүлэх хугацааг **дараа оны 6 сарын 30** болгож сунгана.
- Дээрх үнэ шилжилтийн тайлангуудыг бэлтгэн, татварын албанд хүргүүлэх татвар төлөгчид тавигдах шаардлагын нэг болох борлуулалтын орлогын босгыг 6 тэрбум төгрөгөөс **10 тэрбум төгрөг** болгон нэмэгдүүлнэ. Түүнчлэн энэ босго хэмжээнээс доогуур борлуулалтын орлоготой гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд мөн эдгээр үнэ шилжилтийн тайланг бэлтгэн, татварын албанд хүргүүлэх шаардлагагүй болно.
- Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байсныг 5 хувь болгон бууруулна.



4. ХХОАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон голлох нэмэлт, өөрчлөлтүүд

- Татвар төлөгчийн үйл ажиллагааны орлого, хөдөлмөрийн орлогын нийт дүнд 10%, 15%, 20%-ийн шаталсан татварын хувь хэмжээгээр татвар ногдуулна.
- Аж ахуйн нэгжийн хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид олгосон ногдол ашгийн орлогод 15 хувиар татвар ногдуулна.
- ХХОАТ-ын тайлан /ТТ-06/-г татварын албанаас урьдчилан бэлтгэж, татвар төлөгчид тайланг хянаж засварлах эсвэл баталгаажуулан илгээх боломжтой болно.
- Татвар төлөгчийн үйл ажиллагааны болон хөдөлмөрийн жилийн 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө.
- Суутган төлөгчийн татварын тайланг бэлтгэж, хүргүүлэх хугацааг улирлын тайлангийн хувьд дараа улирлын сүүлийн өдөр, жилийн эцсийн тайланг **дараа оны 2 сарын сүүлийн өдөр** болгон сунгана.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болго. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайланс мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.